

МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧИЙН ЯВУУЛЖ БАЙГАА ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, АШИГЛАЖ БАЙГАА ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХҮН,  
МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНД, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БУЮУ ҮЗҮҮЛЖ  
БАЙГАА НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ;

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь төслийн Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг Байгаль орчны үнэлгээний тухай хуульд заасны дагуу төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ зэрэг баримт бичигт тусгаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. Технологи дамжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт “технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно” гэж заасны дагуу “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлал”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Журам, аргачлал батлах тухай” 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/135 / А/200 дугаар хамтарсан тушаалаар баталж,

Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэгт заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ажиллаж байна. Тус журам аргачлал батлагдсанаар хүнд болон хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн технологийн түвшнийг үнэлэх боломж бүрдэх юм. Байгальд орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх Байгаль орчинд ээлтэй, нийгмийн үр ашигтай тээвэрлэлтийн нөхцөл бүрдүүлэх зорилгоор Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул 19 дүгээр талбайн үйлдвэрлэлийн баазаас Баянхошуу-Өвдөгийн хилийн боомт чиглэлийн 210,7 км хатуу хучилттай авто замыг 4 багцад хуваан барилгын ажлыг гүйцэтгэсэн ба эхний 2 багцын нийт 104 км автозамын барилгын ажлыг БНХАУ-ын Дачин Ойлфийлд зам гүүрийн компани гүйцэтгэж, 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. 3, 4 дүгээр багцын барилгын ажил гүйцэтгэгчээр Монгол улсын “Арж капитал” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажилласан. Тус хатуу хучилттай авто замыг 2016 онд бүрэн ашиглалтад оруулсан ба тус замаар гарын тосны экспортын тээвэрлэлт гүйцэтгэж байна.